



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/ОН

Улаанбаатар хот

Г 2023 оны ээлжийн амралт, орлон ажиллах
хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.5, Хөдөлмөр Нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралт, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан хаагчдын 2023 оны ээлжийн амралтын хуваарийг нэгдүгээр хавсралтаар, орлон ажиллах хуваарийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Албан хаагчдын ээлжийн амралтын олговрыг зохих журмын дагуу бодож холбогдох зардлаас тооцож олгохыг Ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

3. Батлагдсан хуваарийн дагуу ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх, амралтын хугацаанд ажлын чиг үүргийг тасралтгүй, хэвийн үргэлжлүүлэх нөхцөлийг бүрдүүлж, хяналт тавьж ажиллахыг Хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн (П.Отгонцэрэн)-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ